

**2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГА БОЛОН  
ЗДО-ООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 05 дугаар сарын 18-ны “Пүрэв” гарагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
1	Зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод, энгийн, ойлгомжтой хэлбэрээр байршуулах	ЗДТГ, ААНБ-ууд
2	Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх иргэдийн санал асуулгыг тогтмол авч хэвшүүлэх, түүний мөрөөр үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хэрэгжилт үр дүнг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллах.	ААНБ-ууд
<b>ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
3	Нийслэлийн хэмжээнд тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх болон эвдрэл, гэмтэлтэй байгаа автозам болон явган хүний зам талбайг засварлах ажлыг эрчимжүүлж, Үндэсний их баяр наадмаас өмнө бүрэн дуусгах.	ТХҮХ, Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд
4	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын аюулгүй байдлыг хангуулж, ил задгай цахилгаан, кабелин утсыг цэгцлэх, гэмтэлтэй шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг засварлаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, Налайх Эрчим хүч Өндөртолгой хэсэг
5	Инженерийн шугам сүлжээний худгуудын тагны иж бүрэн, аюулгүй байдлыг шалгах, явган хүний зам дээрх худгийн өндөржилт, түвшинг тэнцүүлэх ажлуудаа эрчимжүүлж, хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, УСАТ
6	Үндэсний их баяр наадам, Олон улсын тэмцээн уралдаан, олныг хамарсан арга хэмжээний үеэр гарч болох болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авах, цахилгааны нөөц эх үүсгүүр, насос, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, аюулгүй нөөцийг бүрдүүлж ажиллах.	ТХҮХ, ОБХ, ЦХ Налайх Эрчим хүч Өндөртолгой хэсэг
7	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” А/309 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ногоон бүсийг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, ОБХ, ЦХ
<b>ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД</b>		
8	Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ил задгай архидан согтуурч, танхайрч, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг алдагдуулж байгаад анхаарч, хяналт тавьж ажиллах.	ЦХ
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
9	Хүүхдийн баярыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах урьдчилсан төлөвлөгөөг боловсруулж 2023.05.18-ны өдрийн дотор танилцуулах	НХХ, Боловсролын хэлтэс ГБХЗХХ, Соёлын ордон

10	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, он дамжин хийгдэж буй ажлуудын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах	СТСХ, ХААА
11	Байгууллагуудын гадна гэрэлтүүлгийн цагийн тохиргоог тохируулж, эрчим хүчний хэрэглээг хэмнэх талаар арга хэмжээг хэрэгжүүлэх	ААНБ-ууд
12	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50 м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, цэвэрлэгээг тогтмолжуулах, хайс хашааг угаах, хогны түүвэр цэвэрлэгээг 14 хоног тутамд хийх	ААНБ-ууд
13	Дүүргийн танилцуулгыг салбар тус бүрийн давуу тал, боломж нөхцлийг илэрхийлсэн байдлаар шинэчлэх ажлыг зохион байгуулах	ЗДТГ, ААНБ-ууд
14	Дүүргийн 1, 2 дугаар хороонд төрийн үйлчилгээний “Хурдан” системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан иргэдэд тус системийн хэрэгжилт, авах үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулах	ЗДТГ
15	Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх, мод тарих, ургуулах, төгөлжүүлэх, арчлах, зүлэгжүүлэх ажлуудаа эрчимжүүлж, өмнөх онд тарьж ургуулсан модны ургалтын талаарх үр дүнгийн танилцуулгыг гаргах, ААНБ-ууд 50м <sup>2</sup> - аас доошгүй талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд, ААНБ-ууд
16	Орчны стандарт, аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг дүүргийн гудамж, зам талбайн эвдрэл гэмтэл, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцан, үзлэг шалгалтыг зохион байгуулж өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	ТХҮХ, ААНБ-ууд
17	ЭЭШ-ийн сорил шалгалтыг 2023.05.22-24-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн тул бэлтгэлийг ханган, холбогдох арга хэмжээг авч ажиллах	НХХ, Боловсролын хэлтэс, ХЦС
<b>ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС ЦАГ ҮЕИЙН ХОЛБОГДОЛТОЙ ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
18	НЗД-ын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/402 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогыг зохион байгуулах дэд ажлын хэсгийг байгуулж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Татварын хэлтэс, ААНБ-ууд
19	Модыг мананцаржуулж угаах болон зам талбайн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж, Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ууд